



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 4/764

Баян-Өндөр сум

Г Комисс шинэчлэн байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 400, 2022 оны 480 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, комиссын ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга (Д.Сүхээ)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/195 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2022 оны  
11 дүгээр сарын 07-ны өдрийн  
11764...дугаар захирамжийн I хавсралт

### КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын дарга: -Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Гишүүд : -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, (зөвшилцсөнөөр)
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан
- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн ажилтан
- Нарийн бичгийн дарга: -Эрүүл мэндийн газрын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн

\_ОО\_

Аймгийн Засаг даргын 2022 оны  
11 дүгээр сарын 7-ны өдрийн  
5/764..дугаар захирамжийн II хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ КОМИССЫН  
АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Комисс нь Аж, ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7.1, 9.1 дэх заалтад тус тус заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх ажлыг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Комисс нь үйл ажиллагаанд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлээр тогтоосон зарчмаас гадна дор дурдсан зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

- Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлага;
- Эрүүл мэндийн салбарт баримталж буй тэргүүлэх чиглэл;
- Тусламж, үйлчилгээ үзүүлэгчдээс зохиомлоор үүсгэх эрүүл мэндийн хэрэгцээ, санхүүгийн эрсдэлээс иргэдийг хамгаалах;
- Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангах;
- Ашиг сонирхлын зөрчилгүй байх.

1.3. Комисс нь эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааны өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх ба Эрүүл мэндийн газрын дэргэдэх комиссын ажлын албаны үүргийг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс гүйцэтгэнэ.

1.4. Комиссын бүрэлдэхүүнд эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бодлого, хэрэгжилт, зохицуулалт хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

1.5. Комиссын бүрэлдэхүүнийг эрх бүхий албан тушаалтаны шийдвэрээр томилж чөлөөлнө. Комиссын даргыг аймгийн Засаг дарга томилно. Нарийн бичгийн даргыг Ажлын алба томилно.

1.6. Комисс нь үндсэн чиг үүрэг хэрэгжүүлэхдээ шинжээчдийг татан оролцуулах ба шинжээчийг сонгон шалгаруулж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 хүртэл жилийн хугацаатай томилно.

Хоёр. Комиссын чиг үүрэг, үйл ажиллагаа

2.1. Комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцаа, үйл ажиллагааны чиглэлээр эрүүл мэндийн болон аж ахуйн нэгж байгууллагын мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

2.1.2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бодлого, зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

2.1.3. Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагыг судлаж цаашид баримтлах тэргүүлэх чиглэлийг тодорхойлон саналаа Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ажлын албанд хүргүүлэх;

2.2. Комиссын ажиллах хэлбэр хурал байна. Комиссын гишүүдийн 70-аас доошгүй хувь оролцсон тохиолдолд хурлыг хүчин төгөлдөрт тооцно.

2.3. Эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг нээлттэй хурлаар хэлэлцэж, комиссын гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

2.4. Комиссын дарга нь хурлын төлөвлөгөө, ажлын байранд үнэлгээ хийх ажлын удирдамжийг батлах эрхтэй ба шаардлагатай үед даргын шийдвэрээр төлөвлөгөөнд тусгагдаагүй асуудлыг нэмэлтээр хэлэлцэж болно;

2.5. Комиссын дарга нь хурлын тэмдэглэлийг хянах, хурлын шийдвэр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхтэй.

2.6. Комиссын хэлэлцэх үндсэн асуудал:

2.6.1. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн шинээр байгуулах эрүүл мэндийн, эм хангамжийн байгууллагын төсөлд тусгай зөвшөөрөл олгох комиссын тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлж, албан ёсны хариуг өгөх

2.6.2. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар шийдвэр гаргах;

2.6.3. Өмнөх хурлын шийдвэрийг дараагийн хуралд нарийн бичгийн дарга комиссын гишүүдэд танилцуулж байх

2.7. Нарийн бичгийн дарга комиссын даргын баталсан хурлын төлөвлөгөө, хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулгыг гишүүдэд хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө цахим ба цаасан хэлбэрээр хүргүүлсэн байна.

2.8. Комисс нь улиралд 1-2 удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлан хуралдуулна.

2.9. Комиссын гишүүд хурлаар хэлэлцэх асуудалтай бүрэн танилцаж, саналаа бэлтгэж ирэх ба оролцох боломжгүй тохиолдолд саналаа бичгээр болон цахимаар ирүүлнэ.

2.10. Комисс нь шаардлагатай гэж үзвэл комиссын хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох мэргэжилтэн болон шинжээч, тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг оролцуулна.

2.11. Комисс нь хэлэлцсэн асуудлаар санал боловсруулж, тэмдэглэл хөтөлнө. Хурлын шийдвэр болон тэмдэглэлд комиссын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.12. Комисс нь шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дангаар болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран

хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдол, маргааныг шийдвэрлэн холбогдох арга хэмжээг авна.

2.13. Шинжээчээр ажиллах мэргэжилтнүүдийн мэдлэг, урт чадварын үнэлгээ хийх, түвшин тогтоох шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах

Гурав. Ажлын албаны чиг үүрэг

Ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Ажлын алба тусгай зөвшөөрөл хүсэгчийн ирүүлсэн хүсэлт болон төслийг хүлээн авч баримт бичгийн бүрдэлтийг хянан, шаардлага хангаагүй баримт бичигт дахин тодруулга хийлгэн хүлээж авах

3.1.2. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ирүүлсэн шаардлага хангасан төслийг энэхүү журмын 4.1.1-д заасан дүгнэлтийн хамт комиссын хурлаар хэлэлцүүлэн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан тухайн байгууллагад албан бичгээр хүргүүлэх.

3.1.3. Комиссын хурлаар томилсон орон тооны бус шинжээчийг тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байранд томилон ажиллуулж дүгнэлтийг комиссын хурлаар хэлэлцүүлэх

3.1.4. Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагатай харилцаж, тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлсэн баримт бичиг болон бэлтгэсэн ажлын байртай холбоотой мэдээлэл, лавлагааг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

3.1.5. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын талаар холбогдох хууль эрх зүйн баримт бичиг, олон улсын туршлага, мэдээллийг нягтлан судалж, тусгай зөвшөөрлийн шаардлагыг шинэчлэх сайжруулах санал дэвшигүүлэх;

3.1.6. Шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, сургаж мэргэшүүлэх, арга зүйн зөвлөмжөөр хангах, урамшуулалт олгох харилцааг зохион байгуулах;

3.1.7. Ажлын байрны үнэлгээний арга аргачлал, үнэлгээний хуудсыг боловсруулан батлуулж, тухайн үйл ажиллагааны талаар шинжээч нарт мэдээлэл өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх

3.1.8. Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн шаардлагын хэрэгжилтэнд төрийн захиргааны болон төрийн бус байгууллагтай хамtran явцын хяналтыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хүчин төгөлдөр бус тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураах

3.1.9. Тусгай зөвшөөрлийн бодлого хэрэгжилт зохицуулалт хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөл, эрүүл мэндийн байгууллагуудтай хамtran ажиллаж харилцан мэдээлэл солилцох;

3.1.10. Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаатай холбоотой бүртгэл, мэдээллийн санг хөтлөж, тогтмол баяжуулах;

3.1.11. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, сэргээсэн, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулсан тухай комиссын шийдвэрийг үндэслэн бүрдүүлсэн баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийг комиссын шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд бичилт хийх олгох;

3.1.12. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг захиалах, нэгдсэн журмаар олгох, зааврын дагуу гэрчилгээг хөтөлж, дугаарлах.

3.1.13. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгасан, сэргээсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байгууллагуудаас улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг хүлээн авч, тайланг хуульд заасан хугацаанд нь гарган харьяа орон нутгийн татварын байгууллагад хүргүүлэх ба энэхүү хураамжийг тооцохдоо улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төлбөрийн хэмжээг баримтлах

**Дөрөв. Шинжээчийн чиг үүрэг**

4.1. Эрх бүхий байгууллагаас томилогдсон шинжээчид нь “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5 дугаар зүйлд заасан хяналт, шалгалт хийх нийтлэг үндэслэл, журмыг удирдлага болгон дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн шинээр байгуулах эрүүл мэндийн байгууллагын төсөл, бүрдүүлсэн баримт бичигтэй танилцаж санал гаргах;

4.1.2. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байрны хяналт, үнэлгээ хийж, дүгнэлтийг үнэн зөв гаргах;

4.1.3. Ажлын байранд тавигдах улсын стандартын шаардлага, шалгуурыг хангахтай холбоотой мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тусгай зөвшөөрөл хүсэгчээс шаардлагатай мэдээллийг гаргуулан авах, баримтжуулах;

4.1.4. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шаардлагын хэрэгжилтэд хийх явцын хяналтад оролцох;

4.1.5. Тусгай зөвшөөрлийн шаардлагын талаар холбогдох хууль эрх зүйн баримт бичиг, олон улсын туршлага мэдээлэлтэй танилцаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх;

4.1.6. Энэхүү журмын 4.1.1, 4.1.2-д заасан дүгнэлтийг комиссын хуралд танилцуулах;

4.2. Шинжээчийг сонгохдоо дараах шалгуурыг үндэслэнэ.

4.2.1. Мэргэжлийн болон эрдмийн зэрэг цолтой;

4.2.2. Холбогдох мэргэжлээрээ 10-аас доoshгүй жил ажиллаж мэргэшсэн, байгууллагын удирдлага, зохион байгуулалтаар ажлын дадлага, туршлагатай;

4.2.3. Эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай;

4.2.4. Тусгай зөвшөөрлийн шаардлагын талаар мэдлэгтэй;

4.2.5. Ашиг сонирхолын зөрчилгүй

4.2.6. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

4.3. Шинжээчийг дараах байдлаар сонгож, томилон ажиллуулна.

4.3.1. Шинжээчийн сонгон шалгаруулалтын зарыг шалгаруулалт явагдахаас 21 хоногийн өмнө мэдээллийн хэрэгслээр зарлаж зохион байгуулна.

4.3.2. Сонгон шалгаруулалтыг ажлын албанаас 4.2 –т заасан шалгуурын дагуу үнэлгээний шалгуур хангасан шинжээчийг комиссын хурлаар хэлэлцүүлэн сонгон шалгаруулж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр баталгаажуулж, 2 жилийн хугацаагаар гэрээ байгуулж, үнэмлэх олгоно.

4.3.3.Гэрээ байгуулсан шинжээчдийг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг болон ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур, тэдгээрийг үнэлэх, дүгнэлт гаргахтай холбоотой сургалтад хамруулна.

4.3.4.Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байранд үнэлгээ хийх хуваарийг урьдчилан гаргаж, шинжээчид мэдэгдэн, удирдамж болон шалгах хуудсаар хангаж томилон ажиллуулна.

4.3.5.Шинжээчид тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байрны үнэлгээ ажилласан хугацаа, ажлын үр дүнг харгалзан тооцож ажлын хөлсийг тооцож олгоно.

Тав. Комисс, ажлын алба, шинжээчийн ашиг сонирхлын зөрчлийн шийдвэрлэлт

5.1.Комисс, ажлын албаны бүрэлдэхүүний болон түүнийг төлөөлөх этгээдийн (эцэг эх, эхнэр нөхөр, ах эгч, дүү, хүүхэд, найз нөхөд) тусгай зөвшөөрөл эзэмших өргөдөл гаргагчаар оролцож байгаа тохиолдолд ил зарлан, шийдвэр гаргах, санал хураахад оролцохоос сайн дураар татгалзаж, урьдчилан мэдэгдэнэ.

5.2.Шинжээч нь тусгай зөвшөөрөл хүсэгч иргэн, хуулийн этгээдтэй нэгдмэл сонирхолтой байж болохгүй бөгөөд тусгай зөвшөөрөл хүсэгч нь шинжээчийн хамаарал бүхий этгээд (эцэг эх, эхнэр нөхөр, ах эгч, дүү, хүүхэд, найз нөхөд) байх тохиолдолд шинжилгээ хийхээс сайн дураар татгалзаж, урьдчилан мэдэгдэл гаргана.

5.3.Комисс, ажлын алба, шинжээчдийн бүрэлдэхүүн албан үүргээ гүйцэтгэхэд хөндлөнгөөс нөлөөлсөн аливаа дарамт шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар холбогдох хуульд заасны дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Зургаа.Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаа

6.1.Тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулах;

6.1.1.Тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх төслийг ажлын алба хүлээн авч, комиссын хурлаар хэлэлцүүлж, комиссын хурлын шийдвэрээр шаардлага хангаагүй төслийг шийдвэр гарснаас хойш 1 жилийн хугацаанд дахин хүлээн авахгүй байх

6.1.2.Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байр бэлэн болсны дараа тухайн ажлын байранд дүгнэлт хийх удирдамжийг комиссын даргаар батлуулан гаргуулж, шинжээчдийг сондгой тооны бүрэлдэхүүнтэй хуваарилан төслийг цаасан хэлбэр болон үнэлгээний шалгуур хуудсаар хангана.

6.1.3.Шинжээчид нь томилогдсоноосоо хойш ажлын 5 хоногт багтаан тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичигтэй танилцан, бэлтгэсэн ажлын байрыг улсын стандарт, тусгай зөвшөөрлийн шалгуурын дагуу газар дээр нь хяналт үнэлгээ хийж дүгнэлтийг ажлын албанд ирүүлнэ. Тусгай зөвшөөрлийн комиссын хуралд танилцуулна.

6.1.4.Баримт бичгийн бүрдэл хангалтгүй, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон бол хүсэлтийг Ажлын албанаас буцаана.

6.1.5.Шинжээчдийн дүгнэлт ирснээс хойш ажлын 10 хоногт багтаан комиссын хурлаар дүгнэлтийг хэлэлцүүлнэ.

6.1.6 .Комиссын гаргасан шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан баталгаажуулна.

6.1.7.Ажлын алба нь эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд бичилт хийж, комиссын даргаар гарын үсэг зуруулан баталгаажуулж, аж ахуйн нэгжид олгоно.

6.2.Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад хяналт тавих, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг зохион байгуулах;

6.2.1.Ажлын алба нь тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан чиг үүргийн дагуу гүйцэтгэнэ.

6.2.2.Эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор бүтэц, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт хийж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж өгнө.

6.2.3.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1, 14 зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 19.20, 19.21 дүгээр зүйлд заасан үндэслэл, шударга өрсөлдөөний зарчим, хэрэглэгчийн эрх ашгийг удаа дараа ноцтой зөрчсөн байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг комиссын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийг эрх бүхий байгууллагаар баталгаажуулна.

6.3.Тусгай зөвшөөрлийг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт хийх үйл явцыг зохион байгуулах;

6.3.1.Ажлын алба нь сар бүр тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч байгаа эрүүл мэндийн байгууллагын судалгааг гаргаж хяналт тавих .

6.3.2.Тусгай зөвшөөрлийн шаардлагад хийсэн хяналт, шалгалт болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох санал ирээгүй байгууллагын тусгай зөвшөөрлийг комиссын даргын удирдамжийн дагуу Ажлын алба газар дээр нь үнэлж комиссын хурлаар шийдвэрлүүлнэ.

6.3.3.Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахад тухайн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх төрөл, чиглэл, бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт ороогүй, тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаагүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр өөрчлөх хүсэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигч /иргэн/ нас барсан тохиолдолд төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийр ажлын алба хүлээн авч татварын асуудал эрхэлсэн байгууллагаас мэдээлэл авч судлан гэрчилгээнд бичилт хийн эрх бүхий албан тушаалтан баталгаажуулна.

6.3.4.Тус тушаалын 6.3.3-т зааснаас бусад тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд хийгдэх нэмэлт өөрчлөлтийг комиссын хурлын шийдвэрийг үндэслэн бичилт хийж эрх бүхий албан тушаалтан баталгаажуулна.

#### **Долоо. Тусгай зөвшөөрлийг мэдээлэх**

7.1.Ажлын алба нь тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, нэмэлт өөрчлөлт оруулсан эрүүл мэндийн байгууллагын талаарх мэдээллийг тусгай зөвшөөрлийн мэдээний санд бүртгэн, цахим хуудас (<http://www.mohs.mn>)-ны эрүүл мэндийн

салбарын тусгай зөвшөөрөл, импортын зөвшөөрлийн цахимд суурилсан (licemed) бүртгэлийн программд байршуулна.

7.2. Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын нэгдсэн мэдээллийн санг бүртгэж, баяжуулах үйл ажиллагааг Ажлын алба сар бүрийн 5-ны дотор хийсэн байна.

Найм.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд бичилт хийх;

8.1.1. Гэрчилгээний өвөр талд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр, хаяг, хүчинтэй байх хугацаа, тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар, улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний дугаар зэргийг бичнэ.

8.1.2. Гэрчилгээг олгосон он сар, өдөр гэсэнд комиссын даргын шийдвэр болон шийдвэрийг үндэслэн гаргасан аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалын огноог бичнэ.

8.1.3. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага гэсэн хэсэгт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн болон Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллагын нэр байна.

8.1.4. Байгууллагын нэр гэсэнд эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн нэр, байгууллагын оноосон нэрийг бичнэ.

8.1.5. Үйл ажиллагааны чиглэлд холбогдох хууль тогтоомжид заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааны ерөнхий төрлийг Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйл, эм эммнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн зааж, тухайн байгууллагын тусгайлан эрхлэх үйл ажиллагааны чиглэл, орны хочин чадал зэргийг бичиж тэмдэглэнэ.

8.1.6. Үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр гэсэнд тухайн байгууллагын үйл ажиллагааны хамрах хүрээг заана.

8.1.7. Байгууллагын албан ёсны хаяг гэсэнд тухайн эрүүл мэндийн байгууллагын байршлын хаягийг бичиж тэмдэглэнэ.

8.1.8. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаарт тухайн хуулийн этгээдийг бүртгэсэн гэрчилгээний болон регистрийн дугаарыг бичнэ.

8.1.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байх тохиолдолд зохих байгууллагаас олгосон гэрчилгээний дугаарыг бичиж тэмдэглэнэ.

8.1.10. Гарын үсэг хэсэгт комиссын дарга гарын үсэг зурж эрх бүхий байгууллагын тамга дарж баталгаажуулна.

8.1.11. Гэрчилгээний ар талд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлсэн баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлт болон тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан талаарх бүртгэл, мэдээллийг комиссын шийдвэрийг тус тус үндэслэн бичиж тэмдэглэнэ.

Ес. Хариуцлага

9.1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахтай

холбоотой энэхүү журмыг зөрчсөн аж ахуйн нэгж байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эрх бүхий байгууллагын холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

\_OO\_